

# Фемто секундын өдөөн судлах спектрометрийн аргыг хагас дамжуулагч материалууд дээр хэрэглэн судласан нь

Б.Өлзийбаяр<sup>1\*</sup>, П.Мөнхбаатар<sup>1</sup>, Ц.Хос-Очир<sup>1</sup>, Ц.Баатарчулун<sup>2</sup>, Г.Мөнхбаяр<sup>1</sup>,  
Н.Төвжаргал<sup>1</sup>, М.Отгонбаатар<sup>1</sup>, Г.Эрдэнэ-Очир<sup>1</sup>, Ж.Даваасамбуу<sup>1</sup>

<sup>1</sup>Лазерын судалгааны лаборатори, Физикийн Тэнхим,  
Шинэслэх Ухааны Сургууль, МУИС, Улаанбаатар 210646, Монгол Улс

<sup>2</sup> Геологи-Геофизикийн Тэнхим, Шинэслэх Ухааны Сургууль, МУИС, Улаанбаатар 210646, Монгол Улс

Хоёр ялгаатай өдөөн-судлах (ӨС) схемуудийг өөр өөр фемтосекундын лазерын пульс ашиглан амжилттай хөгжүүлсэн. Хэт-богино пульс лазер ашигласан ӨС схемийг хэрэглэж, хөгжүүлсэн схемийн нарийвчлалыг тодорхойлох болон тохируулга хийх зорилгоор GaAs дахь когерент фононуудын өдөөлтийг хэмжсэн. Энэ когерент фонон давтамжууд нь бусад судлаачдын мэдээллэсэн утгуудтай [1, 2] сайн тохирч байсан. ZnSe болон GaAs-ийг харгалзан нэвтрэлт болон ойлтоор судласан. ӨС туршилтын дохиог хэт-богино пульс лазер ашигласан уед баланслагч фото диодаор хэмжсэн болно. Өөр нэг ӨС туршилтын схемийн хувьд, ZnSe -ийн нэвтрэлтийн өөрчлөлтийг спектрээс нь хамааруулж хэмжих зорилгоор өмнөх ӨС схемд ашигласнаас өөр лазерын үүссүүр ба бүртгэгч ашигласан. Спектрээс хамаарсан ӨС туршилтын схемд хүчтэй пульс лазер ашиглсан хэмжилт мөн амжилттай болсон. Өргөн зурвастай, өндөр-нягтралтай спектрометрээр (HR4000CG-UV-NIR) бүртгэсэн болно.

PACS numbers: 78.47.J-, 78.66.Db

## I. УДИРТГАЛ


1980аад оны эхэн үеэс хойш олон судалгааны багууд оптик пульс өдөөн-судлах аргыг ашиглан фемтосекундын хугацааны хэмжээтэй /нарийвчлалтай/ оптик пульсээр материал системийн хариу үйлчлэлийг судлаж байна[3, 4]. Эдгээр туршилтын хэд хэдэн тохиолдолд, Раман өдөөх процесоор үүсгэгдсэн хэлбэлзлүүд, хоёр фотоны шингээлт ажиглагдсан. Сүүлийн уед фемтосекундын өдөөн-судлах арга нь металл болон хэт дамжуулагчийн судалгаанд ажиглагдаж байна. Хагас дамжуулагч болон металл материалууд дээр хийсэн хэд хэдэн өдөөн-судлах туршилтанда, дээжийн оптик фонон моодуутдай тохирох давтамжуутдай хэлбэлзлүүд ойлтоор (эсвэл нимгэн дээжээр нэвтрэх нэвтрэлтээр) судлах уед ажиглагдаж байсан [5, 6]. Эдгээр хагас дамжуулагч дээжуудийн хэлбэлзлүүдийг импульслэг албадмал Раман сарнилыг агуулсан шугаман бус оптик мэдрэх чадвараар тайлбарладаг [7]. Зарим хагас дамжуулагч дээжууддэд оптик шинж чанарын огцом өөрчлөлт нь хоёр фотоны шингээлтийг агуулсан шугаман бус оптик мэдрэх чадвараар тайлбарладаг [8].

Энэ өгүүллэгт, бид хоёр ялгаатай өдөөн-судлах туршилтын аргын тохируулга хэмжилтийн үр дүнг үзүүллээ. 1-рт, хэт-богино пульс лазертай (6fs-ын үргэлжлэх хугацаатай) өдөөн-судлах туршилтанда ZnSe дахь эгшин зуурын нэвтрэлт, GaAs дахь когерент фононы хэлбэлзлийг хэмжсэн. 2-рт, хүчтэй пульс лазертай (пульсын энерги

нь 1 мЖ) спектрээс хамаарсан өдөөн-судлах туршилтыг ZnSe дээж дээр хийсэн. ZnSe болон GaAs -ийн хувьд өдөөн-судлах туршилтын үр дун нь бусад судлаачдын үр дунтэй сайн тохирсон[1, 10].

## II. ТУРИШИЛТ 1


Энэхүү ажлаар хэт-богино пульс лазерыг ашиглан өдөөн судлах туршилтын схемийн тохируулга хийсэн. Туршилтанда ашиглаж байгаа пульс лазерын төв долгионы урт нь 740nm (1.5эВ) байна. Пульсын үргэлжлэх хугацаа 6 fs. Лазерын давталтын хурд нь 75MHz байх уед пульсын энергийн 4нж. Пульс лазерын спектрийг зураг 1 1 дээр тасархай шугамаар үзүүлэв.



Зураг 1: Пульс лазерын спектр (Rainbow 2)

Туршилтын схемийг зураг 2-т 2т үзүүлэв. Туссан пульсын 1-р цацраг хуваагч (ЦХ)-аар нэвтрэсэн хэсгийг өдөөгч пульс болгож ашиглласан бөгөөд туссан пульсын ойсон хэсэг нь 2-р цацраг хуваагчаар дахин хуваагдсан болно. 2-р цацраг ху


\*Electronic address: ulziibayarb@num.edu.mn



Зураг 2: Хэт-богино пульсын лазер (Rainbow 2) ашигласан нэвтрэлт хэлбэрийн өдөөн судлах туршлагын схем. BS - цацраг хуваагч, TS - шилжүүлэгч хавтан, M - толь, Scan delay - хэлбэлзэгч толь, PC - компьютер, PM - парабол толь, Sample - дээж, BPD - баланслагч фото диод

ваагчаар нэвтэрсэн пульс нь судлагч пульсээр, харин түүнээс ойсон пульс нь харьцуулах пульс болон ашиглагдсан. Гараар тохируулж болдог шилжүүлэгч хавтан дээр суурисан хөдлөгч толь байх бөгөөд түүнээс ойсон өдөөгч пульс нь парабол толины тусlamжтайгаар дээж рүү чиглүүлэгддэг. Харин хэлбэлзэгч толиноос ойсон судлагч пульс нь 2-р цацраг хуваагчаас дахин ойх бөгөөд дээж рүү хавтгай болон парабол толиор чиглүүлэгднэ. Өдөөгч ба судлагч пульсууд нь дээж дээр парабол толины тусlamжтай фокуслагдана. Дээжээр нэвтэрсэн судлагч пульс нь баланслагч фото диод (БФД)-ийн нэг диод руу тусна. Харьцуулагч пульс нь хавтгай толины тусlamжтай БФД-ийн нөгөө нэг диод руу тусна. БФД нь лазерын шуугианыг арилгах замаар судлагч болон харьцуулагч пульсуудын хоорондох эрчмийн маш бага ялгарыг хэмждэг. ЦХ-аар нэвтрэн гарсан өдөөгч пульсыг хаалтаар халхалсан уед БФД дээр бүртгэгдэх дохио “0” байхаар тохируулсан. Ингэснээр өдөөгч пульсээр дээжийг өдөөх уед БФД нь зөвхөн түүгээр үүсгэгдсэн дохиог бүртгэнэ. Энэхүү өдөөгчөөр үүсгэгдсэн дохиог хэлбэлзэгч толь хөдөлж байх явцад хэмжиж авсан. Давтамж нь 1Гц, үр дунг 100 удаагийн хэмжилтийн дунджаар тодорхойлж байгаа болно.

Туршилтын системийн тохируулга хийхээр ZnSe (хаалттай бүсийн өргөн 2.8 эВ) материал дээр нэвтрэлт хэлбэртэй өдөөн судлах туршилтыг гүйцэтгэсэн. Энэхүү дээж нь туссан пульс лазерын спектрийн мужид тунгалаг байдаг материал юм. Өдөөгч пульс, судлагч пульстай ойр




Зураг 3: ZnSe-ийн хувьд хугацаанаас хамаарсан нэвтрэлтийн өөрчлөлт  $\Delta T$

буюу давхцаж байх хугацаанд нэвтрэлтийн өөрчлөлт /зураг 3-т үзүүлсэн/ ажиглагдсан байна.

### III. ТУРШИЛТ 2

Энэхүү ажлаар хэт-богино пульсын лазер (Rainbow 2) ашигласан ойлт хэлбэрийн өдөөн судлах туршлагын схемийг тохируулав. Уг схемийг зураг 4-т үзүүлсэн болно.


Туссан пульсын 1-р цацраг хуваагчаар нэвтэрсэн хэсгийг өдөөгч пульс болгож ашигласан бө-



Зураг 4: Хэт-богино пульсын лазер (Rainbow 2) ашиглсан ойлт хэлбэрийн өдөөн судлах туршлагын схем. BS - цацраг хуваагч, TS - шилжүүлэгч хавтан, Sample – дээж, M - толь, Scan delay - хэлбэлзэгч толь, PM - парабол толь, BPD - баланслагч фото диод, PC - компьютер

гөөд туссан пульсын ойсон хэсэг нь 2-р цацраг хуваагчаар дахин хуваагдсан болно. 2-р цацраг хуваагчаар нэвтрэсэн пульс нь судлагч пульсээр, харин түүнээс ойсон пульс нь харьцуулах пульс болон ашиглагдсан. Гараар тохируулж болдог шилжүүлэгч хавтан дээр суурилсан байх хөдлөгч толинуудаас ойсон өдөөгч пульс нь парабол толины тусламжтайгаар дээж рүү чиглүүлэгддэг. Харин хэлбэлзэгч толиноос ойсон судлагч пульс нь 2-р цацраг хуваагчаас дахин оих бөгөөд дээж рүү хавтгай болон парабол толиор чиглүүлэгдэнэ. Өдөөгч ба судлагч пульсууд нь дээж дээр парабол толины тусламжтай фокуслагдана. Дээжийн гадаргуугаас ойсон судлагч пульс нь хавтгай толиор чиглүүлэгдэн БФД руу тусна. Харьцуулагч пульс нь хавтгай толины тусламжтай БФД-ийн нөгөө нэг диод руу тусна. БФД нь лазерын шуугианыг арилгах замаар судлагч болон харьцуулагч пульсуудын хоорондох маш бага ялгаврыг хэмжих боломжтой байдаг. Мөн БФД нь судлагч болон харьцуулагч пульсуудын хоорондох эрчмийн ялгаврыг хэмжих боломжтой байдаг. Схемийг өдөөгч пульс нь хаалтаар халхлагдсан уед БФД дээр бүртгэгдсэн дохио “0” байхаар тохируулсан байна. Ингэснээр өдөөгч пульсээр дээжийг өдөөх үед БФД нь зөвхөн түүгээр үүсгэгдсэн дохиог бүртгэнэ. Энэхүү өдөөгчөөр үүсгэгдсэн дохиог хэлбэлзэгч толь хөдөлж байх явцад хэмжиж авсан.

Туршилтын системийг тохируулахаар GaAs (хаалттай бүсийн өргөн 1.5 эВ) материал дээр ойлт хэлбэртэй өдөөн судлах туршилтыг гүйцэтгэх болно.




Зураг 5: GaAs-ийн хугацаанаас хамаарсан ойлтын өөрчлөлт  $\Delta R$


гэсэн. Системийн үр дүн нь бага далайцтай когерент хэлбэлзлүүдийг харуулж байна. Давамгайллагч хэлбэлзэл нь 8.8 ТГц-ийн давтамжтай байсан бөгөөд энэ нь бусад туршилтын ажлын мэдээлэгдсэн утгуутай сайн тохирч байна. Энэ нь зураг 4-т үзүүлсэн схем горимоороо зөв ажиллаж байгааг баталж байна.

#### IV. ТУРШИЛТ 3

ZnSe кристалл дээж дээр өдөөгч болон судлагч пульсуудын спектрийн нэвтрэлтийн өөрчлөлтийг янз бүрийн хугацааны хоцрогдолтой хэмжихийн тулд хүчтэй пульс лазер (Solstice Ace) ашиглахад ойлт хэлбэртэй өдөөн судлах туршилтыг гүйцэтгэх болно.



Зураг 6: Хүчтэй пульс лазерын спектр (Solstice ACE)




Зураг 7: Хэт хурдан өсгөгч систем (Solstice Ace) ашиглан спектрээс хамаарсан өдөөн судлах туршилтын схем. BS - цацраг хуваагч, TS - шилжүүлэгч хавтан, M - толь, delay - моторт шилжүүлэгч хавтан, SM - спектрометр, PM - парабол толь, Sample - дээж, PC - компьютер

сан спектрээс хамаарсан өдөөн судлах туршилтыг хийсэн юм. Хэт хурдан өсгөгч систем (Solstice Ace) ашиглан спектрээс хамаарсан өдөөн судлах туршилтыг тохируулсан байгааг зураг 7-д үзүүлэв. Пульс лазерын төв долгионы урт нь 800нм (1.5эВ) байна. Пульсын үргэлжлэх хугацаа 120 фс (35-120фс-ийн хооронд гараар тохируулах боломжтой). Лазерын давталтын хурд нь 5кГц байх уед пульсын энерги нь 1.6мЖ буюу хүчтэй пульс энериgi байна. Пульс лазерын спектрийг зураг 6 дээр үргэлжилсэн шугамаар үзүүлэв.

Энэ туршилтын ажлын хувьд туссан пульс нь цацраг хуваагчаар хуваагдана. ЦХ-аар нэвтрэсэн пульс нь өдөөгч пульс болон ашиглагдана. Энэхүү өдөөгч пульс нь компьютероос удирдагддаг, моторт шилжүүлэгч хавтан дээр суурилсан хөдлөгч толинууд руу тусах ба дээж рүү хавтгай болон парабол толиор чиглүүлэгдэнэ. ЦХ-аас ойсон пульс нь гараар тохируулдаг шилжүүлэгч хавтан дээр

суурилсан толинд ойх бөгөөд хоёр хавтгай болон парабол толиор дээж рүү чиглүүлэгдэнэ. Өдөөгч болон судлагч пульсууд нь дээж дээр фокуслагдана. Судлагч пульс нь дээжийн гадаргууд эгц тусах ба өдөөгч болон судлагч пульс хоорондох өнцөг нь ойролцоогоор  $4^\circ$  болно. Дээжээр нэвтрэсэн өдөөгч пульс нь хоёр дахь парабол толиноос ойсны дараагаар хаалтаар халхлагдана. Дээжээр нэвтрэсэн судлагч пульсыг цуглувж спектрометр рүү илгээхийн тулд өөр нэг парабол толь ашигладаг. Өдөөгч пульстай харьцангуй судлагч пульсын хугацааны хоногдлыг өөрчлөхийн тулд шилжүүлэгч хавтан хөдлөж байх үед судлагч пульсын эрчмийг спектрометрээр хэмжсэн. Дээж (ZnSe)-ийн өдөөгчөөр өдөөгдсөн спектрийн нэвтрэлтийн өөрчлөлт нь зураг 8-д үзүүлсэн эрчмийн хэмжилтээс харагдана.



Зураг 8: Хэт хурдан өсгөгч систем (Solstice Ace) ашиглан спектрээс хамаарсан өдөөн судлах туршилтын схем. BS - цацраг хуваагч, TS - шилжүүлэгч хавтан, M - толь, delay - моторт шилжүүлэгч хавтан, SM - спектрометр, PM - парабол толь, Sample – дээж, PC - компьютер

ZnSe кристалл дээж дээр өдөөгч болон судлагч пульсуудын спектрийн нэвтрэлтийн өөрчлөлтийг янз бүрийн хугацааны хоногдолтой хэмжихийн тулд мөн л хүчтэй пульс лазер (Solstice Ace) ашигласан спектрээс хамаарсан өдөөн судлах туршилтыг хийсэн юм. Пульсын спектрийн мужид тунгалаг байдаг /нэвтрүүлэгч/ ZnSe кристалл нь өдөөгч пульс судлагч пульстай давхцах хугацаанд шингээгч шинж чанартай болж байсан. Иймд энэхүү дээж нь хоёр фотоны шингээлтийг судлахад таатай материал юм. ZnSe дээжийн хаалттай бүсийн өргөн (2.8эВ, [11]) нь пульс лазерын төв давтамжийн энэригийн фотоноосойролцоогоор хоёр дахин их учраас энэ нь хоёр фотоны шингээлтийн процесс байж болно [10, 12].

## V. ДҮГНЭЛТ

Бид өдөөн-судлах туршилтын схемийг хүчтэй пульс лазер (Solstice Ace) болон хэт-богино пульс лазер (Rainbow 2)-ын оролцоотой хөгжүүлсэн болно. Эдгээр хөгжүүлсэн схемээ шалгах болон тохицуулга хийх зорилгоор GaAs дахь когерент фононуудын өдөөлт ба өдөөгчөөр өдөөгдсөн нэвтрэлтийн өөрчлөлтийг хэмжсэн. Уг хөгжүүлсэн схемийг ашиглан хэмжсэн үр дун маань энэ төрлийн бусад судалгааны ажлын мэдээлэгдсэн утуурайтай нийцэж байгаа явдал нь пульс лазерууд болон туршилтын схем маань цаашдын судалгаанд хэ-

рэглэх боломжтойг харуулж байна. Пульс лазерууд нь когерент хэлбэлзэл, дээд эрэмбийн шугаман бус эффект, аттосекундын пульс үүстгэх болон терагерцийн долгион үүсгэх зэрэг үзэгдлийг судлахад хэрэглэх боломжтой.

## ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажил нь ШУТС (Grants No. SSA 014/2016, SSA 017/2016), МУИС-ийн зочин судлаач төсөл (code P2017-2407)-ийн дэмжлэгтэйгээр хийгдэв.

- 
- [1] G. C. Cho, W. Kutt and H. Kurz, Phys. Rev. Lett.**65**, 764 (1990).
  - [2] S. Adachi, J. Appl. Phys. **58**, R1 (1985).
  - [3] E. P. Ippen and C. V. Shank, Ultrashort Light Pulses, edited by S. L. Shapiro (Springer-Verlag, Berlin, 1984).
  - [4] C. B. Harris, E. P. Ippen, G. A. Mourou, and A. H. Zewail, Ultrafast Phenomena Springer-Verlag, Berlin (1990).
  - [5] H.J. Zeiger, J. Vidal, T.K. Cheng, E.P. Ippen, G. Dresselhaus, and M.S. Dresselhaus, Phys. Rev. **B 45**, 768 (1992).
  - [6] S. De Silvestri, J.G. Fujimoto, E.P. Ippen, E.B. Bamble, L.R. Williams, and K.A. Nelson, Chem. Phys. Lett. **116**, 146 (1985).
  - [7] M. J. Rosker, F. W. Wise, and C. L. Tang, Phys. Rev. Lett. **57**, 321 (1986).
  - [8] J. M. Chwalek, C. Uher, J. F. Whitaker, G. A. Mourou, and J. A. Agostinelli, Appl. Phys. Lett. **58**, 980 (1991).
  - [9] H. Kurz, QELS Digest 11, **58** (1991).
  - [10] J. Shen, Z. Zhang, and Z. Hua, Appl. Phys. Lett. **88**, 011113 (2006).
  - [11] D. J. Chadi, Phys. Rev. Lett. **72**, 534 (1994).
  - [12] X. Wan, X. Yao, M. Wang, and H. Hao, J. Electroceramics **21**, 737 (2008).